

**ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН НЭЭЛТТЭЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД
2014 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан эсэх, хуулийн хэрэгжилтийг олон нийтэд веб сайт ба бусад арга хэрэгслээр тайлагнасан байдал;	Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн хуулийг иргэдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр сурталчлан таниулах зорилгоор асуулт, хариулт хэлбэрээр тус бүр боловсруулан байгууллагын цахим хуудас болон үйлчилгээний байруудын мэдээллийн самбарт сар бүр нийт 12 удаа байршуулав. Мөн уг хуулийг хувилж, 21 аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн хэлтэс нэгжүүдэд хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар дотоод албан бичгийн хамт хүргүүлсэн.
2.	Байгууллагын боловсруулж буй хууль, дүрэм, журмын төслийг веб сайт ба бусад хэлбэрээр олон нийтэд хүргэж, санал авсан байдал;	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газар 2014 оныг эрх зүйн шинэтгэлийн жил болгон зарлаж, бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутам хэрэглэгддэг гурван гол хууль болох Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн бусад бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж УИХ-аар батлуулахаар зорилт тавьсан.</p> <p>Уг ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг намрын чуулганаар хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн барьж анхны хэлэлцүүлэг нь хийгдээд байна. Үүнтэй холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд нийт 20 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр ажлын хэсгээс мэдээлэл хийж, хуулийн төслийн явц, гарах үр дүнгийн талаар мэдээлэл хүргэж ажиллав.</p> <p>Мөн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль зүйн яамнаас боловсруулан төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод, иргэдийн саналыг авахаар 70 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгийн арга хэмжээг Eagle, ubs, c1, etv, Монголын радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг урьж оролцуулан, мэдээ сурвалжлага бэлтгүүлж нийтэд хүргэлээ.</p> <p>Түүнчлэн дээрх хуулийн төслүүдийг байгууллагын https://burtgel.gov.mn цахим хуудасын “Хэлэлцүүлэг булан”-д байршуулж иргэдийн санал, хүсэлтийг</p>

		хүлээн авснаас гадна Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд мөн санал хүсэлт авсан болно.
3.	Байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм, бусад дүрэм журмыг веб сайт болон хэвлэмэл байдлаар тараасан эсэх;	<p>- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2013 оны 1450 дугаар тушаалаар “Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журмыг мөрдөж ажиллах тухай дотоод албан бичгийг тус газрын бүх салбар, нэгжид хүргүүлж, танилцуулсан. Мөн ерөнхий газрын нийт албан хаагч нарт нийт 11 удаагийн дотоод сургалт, мэдээллийн цагаар дамжуулан Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм болон бусад дүрэм журмыг танилцуулсан.</p> <p>- Иргэд болон бүртгэлийн ажилтныг хууль, эрх зүйн мэдээллээр хангахтай холбогдуулж байгууллагын цахим хуудаст Хууль зүйн сайдын 1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар энэ онд батлагдсан нийт 14 дүрэм журам, заавар шинэчлэн байршуулав. Үүнд:</p> <p><u>Хууль зүйн сайдын тушаалаар</u> Иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөх журам , <u>УБЕГ-ын даргын тушаалаар</u> Монгол улсын иргэний үнэмлэх олгох, түүнд мэдээлэл оруулах, бүртгэл хөтлөх журам, Иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөх журам, Иргэний улсын бүртгэл хөтлөх журамд өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох технологи ажиллагааны журамд өөрчлөлт оруулах тухай, Барьцаалбарын загвар , маягтууд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим систем (erps)-д журам батлах тухай, Иргэний баримтын архивын үйл ажиллагааны журам, Бичиг баримт нягтлан шалгах арга зүйн комисс /Зөвлөмж/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх улсын бүртгэлийн төв архивын газрын баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын дүрэм, Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт, Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай, Архивын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, Улсын бүртгэлийн газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрэм зэрэг болно.</p> <p>- Эдгээр дүрэм, журмыг нийт албан хаагч нарт танилцуулж, мөрдүүлэхтэй холбогдуулан 2014 онд нийт 10 гаруй дотоод албан бичиг, чиглэлийг тус тус хүргүүлж ажилласан.</p>
4.	Иргэдээс тухайн байгууллагын болон түүний үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэрхэн авах тухай мэдээллийн хуудсыг	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын бүртгэлийн үйлчилгээний төрлүүдийн талаарх гарын авлага брошур нийт 54000 ширхэг, Бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890, https://burtgel.gov.mn цахим хуудасын нэрийн хуудас, плакат 3500 хэвлүүлэн

	<p>боловсруулсан эсэх, веб сайт буюу бусад арга хэрэгсэлд байршуулж, хэвлэж тараасан эсэх;</p>	<p>үйлчилгээний байрнууд болон аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрнуудаар байршуулж иргэдэд тараан ажиллав. Мөн төв байр болон үйлчилгээний 1, 2, 3 дугаар байранд мэдээллийн самбар, стэнд зэргийг байршуулж иргэд болон албан хаагчдийг холбогдох мэдээллээр ханган ажиллалаа. Дээрх гарын авлага, брошураас тус онд нийт 34923 ширхэгийг иргэдийн гарт хүргэж, тараагаад байна. Түүнчлэн байгууллагын цахим хуудасны нүүрэн хэсэгт “Вебийн бүтэц” гэсэн тусгай цонхийг шинээр нээж, цахим хуудас дахь мэдээллийг цогцоор нь багтаасан жагсаалтыг байршуулж өгсөн. Энэ нь иргэд байгууллагын цахим хуудаснаас өөрийн хүссэн мэдээллийг харахын тулд ямар цонхны аль хэсэгт байгааг мэдэх бүрэн боломжтой болсон.</p>
<p>5.</p>	<p>Тухайн байгууллагын үйл ажиллагааны талаар сар бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд мэдээлэл хийсэн байдал;</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний мэдээллийн нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт бусад цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, сурталчилан тус газрын удирдлага, албан тушаалтнуудыг нэвтрүүлэг, ярилцлагад оролцуулж ажиллав. - Тайлант хугацаанд нийт 58 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 253 удаагийн сурталчилгааг телевиз, мэдээллийн цахим сайт, өдөр тутмын сонингоор дамжуулан олон нийтэд хүргэсэн. Тухайлбал, - ТҮЦ машинаас олгож буй лавлагаа болон гадаад паспортыг гараас гараас гарт, гэрийн хаягаар хүргэж буй үйлчилгээний талаар мэдээлэл хүргэхийн зэрэгцээ иргэний цахим үнэмлэхийг ТҮЦ машинаар захиалах боломжтой болох, бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хорооноос авч болох талаар болон хууль, эрх зүйн шинэчлэл хийгээд цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлыг сурталчлах зорилгоор Монголын Үндэсний телевиз, Ubs, tv5, Sbn, C1, Eagle, Bloomberg, MN25, Эх орон, ntv, Шинэ монгол телевиз, Монголын фм-үүдийн холбоонд давхардсан тоогоор нийт 36 нэвтрүүлэгт оролцож, ярилцлага өгөв. - Улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтаж “Big country” фильм студиэр “Нэг иргэн-нэг бүртгэл” 20 минутын тусгай нэвтрүүлгийг захиалан хийлгэж, Монголын Үндэсний телевиз, TV5, Eagle, TV10, NTV зэрэг телевизээр гаргаж олон нийтэд хүргэсэн. - Үндэсний шуудан, Алтангадас сэтгүүл, “Монголын фм”-үүдийн холбоотой мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Бүртгэл ба хууль” сэдэвт өөрийн байгууллагын 30 минутын мэдээллийн тусгайлсан цагаар улсын бүртгэлийн холбогдох албан тушаалтнуудыг сар бүр оролцуулан иргэд олон нийтэд тогтмол мэдээлэл өгч хэвшлээ.
<p>6.</p>	<p>Иргэдээс өргөдөл, гомдлыг хүлээн</p>	<p>Тус газар нь иргэдийн өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч холбогдох хууль,</p>

	авах арга хэлбэр, цахимаар авч буй байдал;	тогтоомжид заасны дагуу шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын https://burtgel.gov.mn цахим хуудас дахь “онлайн1890” мессенжэр хаягаар шаардлагатай тохиолдолд хүлээн авч байна.
7.	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийдэг тогтолцоо бүрдүүлсэн байдал;	<p>- Тус байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээг дотоод газар, хэлтэс, нэгжүүдээс сар бүр хүлээн авч, хяналт тавьж, тайланг нэгтгэн шийдвэрлэлтийн мэдээг Хууль зүйн яаманд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээтэй Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга тогтмол танилцаж, улмаар 14 хоног тутмын шуурхай хуралдаанд оруулж, асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох газар, хэлтсийн удирдлагуудад үүрэг, чиглэл өгч шийдвэрлүүлж хэвшээд байна.</p> <p>- Тус газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь чиг үүрэг, төлөвлөгөө болон Хууль зүйн яамны Төрийн захиргааны удирлагын газрын даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийг өгдөг болсон.</p> <p>- Энэхүү ажлын хүрээнд “Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэсэн байдал”-д 2014 онд хийгдсэн хяналт-шинжилгээний илтгэх хуудсыг холбогдох газар, хэлтэст дотоод албан бичгийн хамт хавсралтаар хүргүүлэн ажилласан.</p>
8.	Байгууллагаас шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын дүн мэдээг нийтэд веб сайт ба бусад арга хэрэгслээр түгээсэн байдал;	Тус газар нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээг сар бүр байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна. 2014 онд нийт 11 удаагийн мэдээг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан.
9.	Байгууллагын “Нээлттэй бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний биелэлт;	“Нээлттэй бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн 2014 оны ажлын тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

